

гаанд холбогдох он цагийн өч төчнөөн үйл явдлуудыг гэрчлэх түүхийн чухал дурсгалт газар билээ.

БӨХИЙН НУТАГ ШИЛИЙН ГОЛ

М. Зэнээ

ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийг бөхийн өлгий нутаг гэж өвөр монголчууд ярих дуртай.

«Үдшээр гардаггүй цолмон од нь
Үүрийгээ цайхаар гялалзаад байна
Үзэмчин хошууны Дүүрэнзанаа

Үзүүлмээр, зайлмаар хаялаад байна...» гэсэн ардын дууг Өвөр Монголд дуулдаг. Дуунд гарч байгаа Дүүрэнзанаа бол Шилийн гол аймгийн алдарт бөх байсан билээ. Энэ алдарт бөхөө ард түмэн нь хайрлан магтаж, түүгээр бахархасан сэтгэлээ ардын дуундаа оруулан үеэс үед хүндэтгэн дуулж ирсэн нь энэ билээ.

Өвөр Монголд явагддаг Монгол бөхийн барилдаан нь БНМАУ-д барилдах үндэсний бөхтэй адил боловч өмсгөл, хийх мэх, унагах дүрэм зэргээр нэлээд өөр байдаг. Тухайлбал өвөр монгол бөхөд шуудаг байхгүй, түүний оронд буурны зогдор дууриалган хийсэн маш өргөн дээгүүрээ хуниастай олон нугалаа болсон өргөн өмд буюу туухуу өмсдөг. Зодог нь богино ханцуйтай, хоёр давхар булгаараар хийсэн, дээрээ гууль, мөнгөн товруутай, ар нуруун дээрээ дөрвөлжин тольтой байдаг. Өвөр Монгол бөх нь гараанд гарахдаа орсон буурын шогшоог дууриасан, үсэрч дэвхэрсэн байдалтай буурын шаваа дэвээг санагдуулам байдаг бол халх монголын бөхчүүд Хангарьд шувууны дэвэлтийг дууриасан байх жишээтэй. Өвөр Монгол бөх хөлөөр хөлд, гараар цээжинд мэх хийх бөгөөд гараар хөлд мэх хийдэггүй ба гар газар хүрвэл унасанд тооцно. Өвөр Монгол бөх товших, хавсрах, цохих, дэгээдэх, өсгийдэх, давхар хавсрах, тонгорох зэрэг мэх голлон хийдэг. Өвөр Монголд монгол үндэсний бөхөөс гадна самбо шиг барилдаж, оноогоор хождог хятад маягийн бөх гэх бас явагддаг.

Манжийн Чин улсын үед алдаршиж байсан сайн бөхчүүдийн нэг бол Шилийн голын үзэмчин зүүн бэйл хошууны Анчуу юм. Тэр Чин улсын их наадамд түрүүлж алдар нэрээ түүхэнд үлдээсэн байдаг. Анчууг залгасан олон сайн бөх төрсний дотор ихэд алдаршсан нь Баатарцогт, Дүүрэнзанаа, Багшийн-Улаан, Манх, Хархүүхэн, Готов, Арван зургаат Чойжамц, Борбаатар, Шарбаатар, Жаахан Нямаа, Янзган-Ёндон, Хотолбаяр, Хүрээ Баянцогт, Хүрээ Сэнгээ, Мөөхий Сэнгээ зэрэг бөхчүүд юм. Тэд аймаг хошуу, чуулганы наадамд олонтаа түрүүлж байсан дархан аврагууд билээ.

Нутгийн настайчуудын ярихаар бол Багшийн-Улаан гэдэг бөх өвдөг шороодож үзээгүй гэдэг. Ийм бөхийг нутгийнхан «туухуу зодогт нь тоос хүрч үзээгүй бөх» гэж ярилцдаг байна.

Өвөр Монгол бөхчүүд өөр нутаг усанд очиж барилдахдаа Чингисийн үеийн алдарт бөх Бэлгүүтэйн бөхийн хэрэглэл хадгалсан хэмээх газар очиж мөргөн биеэ даатгадаг байсан уламжлалтай. Энэ

бол монголчууд эрт цагаас аварга бөхийнхөө эрдэм чадалд хүндэтгэн биширч, хүлцэнгүй залгамжилж ирснийг харуулж ажээ. Одоо ч Шилийн голын Баруун үзэмчин хошуунд «Бөхийн овоо» хэмээх тахилгын газар байсаар байна.

Шилийн голын Баруун үзэмчин хошууны биеийн тамирын зөвлөлийн ажилтан Жавхлант бол алдарт бөх Дүүрэнзанаагийн 5-р үеийн удам бөгөөд түүний ээж «тасархай бөх» гэж нэрлэгдэж байсан Дүүрэнзанаагийн туухуу, зодог, гутлыг вааданд боож бурханыхаа хажууд тавин тахиж байсныг «Соёлын хувьсгал»-ын үед улаан хамгаалагчид булаан авч дотор нь будаа хадгалж байсан жишээ бий. Энэ алдарт бөхийн нутгаас төрсөн олон бөхчүүдийн дотроос Үзэмчний Борбаатар, Хүрээ Сэнгэ хоёр 1934 онд Шанхайд очиж хятад бөхийн манлай болж түмэнд гайхагдаж байсан ба 1936 онд Өвөрлөгч 49 хошууны 9 шилдэг бөх Японд үзүүлэх барилдаан хийж байсан байна. Нэрт бөх Эсрэн, Сэнгээ нар Хятад, Японд хамгийн шилдэг бөхчүүдийг нь дор нь ялж нэр алдраа мандуулж байсан гэж өвөрмонголчууд ярих дуртай.

«Соёлын хувьсгал»-аас өмнө ӨМӨЗО-д төрсөн 17 аврагын 13 аврага нь Шилийн гол нутгаас төрсөн Үзэмчний бөхчүүд байв. Аварга бөх Сэнгээ, Содном, Гуашарав, Лоорой нарыг Хөх нуур, Аньхуй, Шаньси, Синьзян зэрэг бөх султай газар урьж багшлуулж байлаа. 1957 онд ӨМӨЗО байгуулагдсаны 10 жилийн ойгоор дархан бөх Эрхэмбат баяр наадмын бөхийн манлайд дэвж түрүүлж байсан билээ. Эрхэмбат Шилийн гол аймагт анхны нэгдлийн тулгын чулуу тавьсан улс төрийн нэртэй зүтгэлтэн, алдартай бөх боловч «Соёлын хувьсгал»-ын 10 жилийн самууралд туйлын хортой хэлмэгдэж харамсалтайгаар таалал төгссөн юм.

1958 онд аврага Сэнгээ, Содном, Адъяа (Хөлөн буйр) нарын гурван бөх БНМАУ-д Өвөр Монголын ард түмний халуун сэтгэлийг өвөрлөн ирж алтан Туулын соргог дэнж Буянт-Ухаа дээр үзүүлэх барилдаан хийж байсан нь саяхан мэт санагдана. Гэтэл монгол үндэстний уламжлалт эрийн гурван наадмыг БНХАУ-д явагдсан улс төрийн элдэв будлианы гайгаар хийх нь багассаар «Соёлын их хувьсгал» гэгчээр бүр зогссон юм. Энэ бол Хятадын хэвлэл, радиогоор сурталчилж байгаа нөгөө улигт Линь Бяо «Дөрвөн хүний бүлэг»-ийн хорлолоос болсон байна. Энэ хорлолыг амссан олон хүний нэг болох алдарт бөх Эрхэмбатын тухай өгүүлэхэд л «Соёлын хувьсгал» гэгч ямаршуу хөнөөлтэй үйл явдал болсоныг бид төвөггүй ойлгож болно. Алдарт бөх Раднаагийн Эрхэмбат 1955 онд Шилийн гол аймгийн Баруун үзэмчин хошуунд «Эх булаг» нэртэй анхны нэгдэл байгуулж хөдөлмөрөөрөө алдаршиж байсан хүн юм. Тэр 1966 он хүртэл Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын гишүүн байжээ. Р. Эрхэмбат нэг жилийн олон хошуу наадамд 11 удаа дараалан барилдаж 9-д нь түрүүлж, 2-т нь үзүүрлэж байсан нэртэй бөх юм. Өндөр Том биетэй, өргөн ханхар цээжтэй, хүч бяр ихтэй сайхан бөх байсан боловч 1966 оны «Соёлын хувьсгалаар» эхний 2 жил шүүмжлэгдэж, дараа нь «Хар малгай» гэгчийг өмсөн бүх тушаалаасаа бууж, ямар ч эрх чөлөөгүй болжээ. «Хар малгай» гэгчийг өмсөхөөрөө хүнтэй үг солих эрх байхгүй, хүнтэй таарвал өмнө нь очиж толгойгоо бөхийлгөн зогсож нүглээ наминчлах ёстой болдог байжээ. 7 жил хатуу дэглэмд, 2 жил энгийн ялтан гэгдэж, зовж зүдэрч явахдаа тэргэнд хөллүүлж морь, малын үүрэг гүйцэтгэж явсан байна. Тэргэнд хөллөсөн 3 хүний голд Эрхэмбат гуай зүтгэж чулуу мод, ус түлээ бүх юм зөөн шогшихдоо «Тэргэний голын хүрэн» нэртэй болжээ. «Дөрвөн хүний бүлэг»-ийн явуулсан гэх энэ улс төрийн дам-

пуурал энгийн номхон ард иргэдийг тамлан зовоохдоо хийсэн хэрэг гэж тулгах зүйл олохгүй болохоор «ялын сэжиг» бүхий этгээд хэмээн тамладаг байлаа.

Р. Эрхэмбатыг 4 төрлийн ялын сэжигтэй этгээд гэж үзэж байлаа. Энэхүү 4 ялын 1-рт: тэр баян байсан. 2-рт: Улаанхүүгийн шадар байсан. 3-рт; Анхны нэгдэл байгуулсан. 4-рт: Ревизионист. Яагаад гэвэл төрсөн дүү нь Ар Монголд байдаг хэмээн тамладаг байжээ. Эрхэмбатын төрсөн дүү Р. Өлзийбаяр БНМАУ-д бас л анхны нэгдлийн тулгын чулуу тавилцаж, Ардын Их хурлын депутатаар сонгогдож явсан манай нэртэй ахмад коммунист билээ. «Соёлын хувьсгалын» хүнд хэцүүг бие сэтгэлээрээ туулж өнгөрөөсөн Эрхэмбат гуай «энэ хувьсгал хүн голохгүй нийтлэг байсан. 80 настай хөгшин ч, 8 настай балчир ч өртдөг байлаа. Өдөржингөө ажил хийгээд орой улайдтал халсан пийшин дээр нүүрээ тулган тонгойж, шатаж үхэх шахна. Хамаг хөлс асгаж, амь тэмцэж байхад халууцаж байна уу? гэж асууна. «Тиймээ» гэхээр сэрүүцүүлнэ хэмээх хүйтэнд түлхэн гаргаж, хөл гар хөлдөөнө. Ийм тамлалаас болж халуун хүйтэн харшаад улаан хоолойны рак болж сүүлдээ хоол орохоо больжээ. Тамлаж, тарчлаах үед олон удаа ухаан алдан унаж байсан нь эцэстээ биегүй болгож, ходоодоо цоолуулан гуурс хийлгэж, өдөрт нэг литр хэр бантан гуурсаар хийж амь зууж байна» гэж дүүгээ очиход ярьсан нь «соёлын хувьсгал»-ын үеийн наад захын үнэн байдлыг уншигч олонд тодорхой ойлгуулах ажээ. Тийм ч учраас Хятадын ард түмэн «Соёлын хувьсгалыг» феодал-фашист диктатур гэж зүй ёсоор нэрлэж байсан нь тодорхой. Линь Бяо «дөрвийн бүлгийн тэнгэр тулам ял хэмээн хэвлэлд бичдэг нь ч үүнтэй холбоотой. Тэд хүнийг цахилгаан гүйдлээр цохиулах, нүцгэлж дээл нөмөргөөд хоёр хүнийг ар нуруугаар нь хүлж шатдаг тосонд дүрсэн амьд болжмор асаан хормой дотор нь хийх элдэв муухай тамлал сэддэг байсан тухай олон хүмүүс арга барагдан ярьж байсныг 1970—1980 онд миний бие судалгаа хийж явахдаа цөөнгүй хүмүүсээс сонсож явснаа санаж байна. Амь тэмцсэн болжмор хорхой дотор шатахдаа дээшээ л хөөрөөд байхаас доошуу бууна гэж байхгүй, нүцгэн биенд хүрсэн газар болгоноо түлнэ. Адилхан зовсон хоёр амьтан болохоороо болжмор хурдан шатаж үхээсэй л гэж залбирдаг байсан гэж энэ тамлалыг биеэр үзсэн хүмүүс ярьж байсан билээ. Ийм хүнд хэцүү зовлон туулагчдын нэг Хятадын ардын их хурлын гишүүн, Бүх Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн Эрхэмбат гуай нас барахаасаа өмнө төрсөн дүүтэйгээ уулзах ганц хүсэлт тавьсаныг Хятадын засгийн газар манай улсад уламжилж манай нам, засаг түүнийг нь биелүүлж өгсөн билээ.

Эрхэмбат гуайн бие муу байхад түүнд «Дархан бөх» цолыг нь өгч, шагнал урамшил олгон сэтгэлийг нь засах ажил хийсэн боловч олон жилийн хүнд хэцүү тамлалаас үлдсэн уршигт өвчин нь газар авч 1982 онд харамсалтайгаар таалал төгссөн юм.

Шилийн голын алдарт бөх Дүүрэнзанаагийн залгамж болсон дархан бөх Эрхэмбат ийнхүү нэг насны амьдралаа цагаасаа өмнө харамсалтайгаар дуусгасан боловч тэднийг залгамжлах залуу халаа өнөөдөр ч Шилийн гол нутгаас төрж тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлсээр байна. 1977 онд ӨМӨЗО-ы 30 жилийн ойгоор түрүүлсэн 27 настай Эрдэнэбаяр бас л Шилийн голын малчны хүү байгаа нь Дүүрэнзанаагийн бөхийн удам тасрахгүйн бэлэг тэмдэг болж байна. Сүүлийн хэдэн жил тогтмол сайн барилдаж байгаа Шилийн голын бөхчүүдийн тоонд Эрдэнэбаяр, 1989 онд БНМАУ-д ирсэн Гончигжав,